



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 24 № 3/552
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



МТШХХГ-ЫН ХАРЬЯА “РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:

Аудитор: Баярмаа
Утас: 261885
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар 21

Аудитын тайлан

Хавсралт 1: Дуусвар тайлан

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: МЗ-ийн хариу

Хавсралт 5: Аудит хийсэн санхүү, төсвийн
гүйцэтгэлийн тайлан, тодруулга

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

Хавсралт 7: Үйлчлүүлэгчийн албан бичиг,
санхүүгийн тайлан, тодруулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Тайлбар захидал
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд /САГ-2017/15/СТА-УТҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 3 дүгээр сарын 10-наас 2015 оны 3 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 09-нд “Ди Эй Би Жи Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Ди Эй Би Жи Аудит” ХХК аудитыг 2017 оны 3 дугаар сарын 10-наас 2017 оны 3 дугаар сарын 20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 25-нд “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-т хүргүүлнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын удирдлага нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Харилцаа холбооны тухай”, “Радио долгионы тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. ТӨХ-ны 2015.04.09-ний өдрийн 230-р тогтоолоор тус газрын нэрийг өөрчлөн дүрмийг шинэчлэн баталсан байна. Санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль НББ-ийн тухай хууль нь шинэчлэгдэн 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын гол зорилго нь “Харилцаа холбоо, мэдээлэл технологийн шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчдийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг нь хангасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан Радио,

Телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх”-д оршино. Үйл ажиллагааны зорилтоо биелүүлэхэд дараах хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ”
2. Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2-т “Улсын төсөвт байгууллага нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах;

гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 36-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрсдөө боловсруулан газрын даргын 2015 оны 185-р тушаалаар батлуулан санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Салбар байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийг “Acoulos”, нэгтгэсэн санхүүгийн тайланг Plastic санхүүгийн програмаар хөтөлж, төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэн гаргасан. Нэгтгэсэн санхүүгийн тайланд СС-ын 2006 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэн гаргах маягт, аргачлал, “Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах” НББОУС-27-г бүрэн хэрэгжүүлээгүй алдаатай байсан тул аудитын явцад зөвлөмж өгч тайланг залруулан гаргуулсан болно.

Тус байгууллагын төв байгууллага нь Улаанбаатар хотод, Баянөлгий, Дорнод, Хөвсгөл, Говьалтай, Өмнөговь 5 аймгуудад салбартай бөгөөд тус тусдаа тайлан гаргаж, нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-ын дагуу хугацаанд гарган ирүүлсэн. Баянөлгий, Хөвсгөл, Өмнөговь аймгуудын санхүүгийн тайланд ҮАГ-аас Итгэмжлэл үзүүлж, Зөрчилгүй санал дүгнэлт, Дорнод аймгийн санхүүгийн тайланд Нью капитал тэнцэл Аудит ХХК аудит хийж, Зөрчилгүй санал дүгнэлт ирүүлсэн байна. Манай компаний хувьд Говьалтай аймаг, Улаанбаатарын санхүүгийн тайланд болон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийсэн.

Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэн гаргах санхүүгийн програмын системийн үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг байдал:

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн шатанд тайлант оны батлагдсан төсвийн зарцуулалтын 0.2 хувиар 11,157.7 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд тайлант оны төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг материаллагын түвшинг тогтоох суурь болгон сонгож, 0.2 хувиар тооцон материаллагын түвшинг 10,436.4 мянган төгрөг гэж тогтоосон. /ТАБ-СТА-В-1/

/мян.төг/

Данс	Материаллаг байдал	
	Төлөвлөлтийн шатанд	Жилийн эцсийн аудитад
Төсвийн зарцуулалт	11,157.7	10,436.4

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг нь үнэлсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед ҮР НӨЛӨӨТЭЙ гэж тооцсон ба дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналтын үйл ажиллагаа ДУНД байна. /ТАБ-СТА-А-1/

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны төсвийг МТШХХГ-аас 3,734,052.4 мянган төгрөгийн төсвийн санхүүжилттэй, 1,892,811.4 мянган төгрөгийн өөрийн орлоготой, 5,578,864.1 мянган төгрөгийн зарлагатай ажиллахаар баталсан байна.

2016 онд 3,726,801.4 мянган төгрөгийн төсвийн урсгал санхүүжилттэй, 1,619,624.2 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны, 232,437.4 мянган төгрөгийн хөрөнгө өмчийн орлоготой, 5,218,184.2 мянган төгрөгийн зардал гаргаж, 360,679.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан байна.

Хэдийгээр төсвийн зарцуулалт нийт дүнгээр хэмнэлттэй ажилласан ч өөрийн үйл ажиллагааны орлого 273,187.2 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан үзүүлэлттэй байна.

Нийт төсвийн зарцуулалтын 40.2 хувийг цалин, 17.6 хувийг ашиглалтын зардлууд, 16.2 хувийг урсгал засварын зардал, 2.6 хувийг мэдээлэл технологийн зардал, 2.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 5.4 хувийг хөрөнгө оруулалтын зардлууд эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-ны өдөр батлагдаж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Тус байгууллага нь тайлант онд шилэн дансны мэдээллийг 5 хавсралтын дагуу мэдээлсэн. 2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, худалдан авалтын тайлан,

худалдан авалтын үйл ажиллагааны мэдээлэл, тушаал шийдвэрүүдийн мэдээллийг оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 34 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Тогтоосон эрсдлүүдээс дараах эрсдлүүдийг гол гэж үзэн нарийвчлан шалгасан:

- Өөрийн орлогыг аккрузль сууриар бүртгэж, тайлагнаагүй байх
- Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байх, үлдэгдлийг баталгаажуулаагүй, зөрүүтэй баталгаажуулсан байх
- Батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зөвшөөрөлгүй, зориулалт бусаар зарцуулсан байх
- Нормативт болон лимиттэй зардлуудыг хянаагүй, хэтрүүлэн зарцуулсан байх

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Тайлант онд тус байгууллагын хувьд дараах материаллаг хэмжээний ажил гүйлгээ гарсан байна.

Үндсэн үйл ажиллагаа нь АНУ дуу хоолой нэвтрүүлэг цацсаны орлого нь 448,402.5 мянган төгрөгийг гадаадын байгууллагаас, Радио, FM, арилжааны телевизүүдийн нэвтрүүлэг дахин дамжуулсан 1,007,910.0 мянган төгрөг нийт 1,456,312.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас 1,198,617.1 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөө 257,695.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Тайлант онд телевизүүдийн нэвтрүүлэг дахин дамжуулах гэрээнүүд цуцлах тухай албан бичгүүд ирсэн учир орлогыг бүрэн бүртгэж тайлагнаагүй байна. Албан бичиг ирсэн ч балансын гадуур борлуулалтын авлага бүртгэж байгаа бөгөөд хууль хяналтын байгууллагад хандвал үйлчлүүлэгч, хэрэглэгчгүй болж үйл ажиллагаа доголдохоос мөн их хэмжээний найдваргүй авлага үүсэхээс болгоомжилж байгаа талаар тайлбар ирүүлсэн.

Нийт 33 байгууллага, хувь хүмүүсээс авах 240,760.6 мянган төгрөгийн авлага тайлагнаснаас 3 байгууллагын 3,009.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан. Аудитын тулган баталгаажуулалтын түүвэрт 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 8 байгууллагын 197,068.2 мянган төгрөгийн авлагыг хамруулсан бөгөөд үүнээс 2 харилцагчийн 20,600.0 мянган төгрөгийн дутуу бүртгэсэн гүйлгээг залруулан бүртгэж, 48,051.2 мянган төгрөгийн баталгаажуулаагүй үлдэгдэлд насжилтын тайлан гаргуулан хянасан.

Нийт төсвийн зарцуулалтыг батлагдсан төсвөөс 360,679.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт 5,218,184.2 мянган төгрөгийн урсгал төсвийн санхүүжилтээс 2,313,924.7 мянган төгрөгийг цалин нийгмийн даатгалын шимтгэлд, 921,394.9 мянган төгрөгийг ашиглалтын зардалд, 138,489.5 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, 119,777.6 мянган төгрөгийг төлбөр хураамж, жижиг татварт, 286,286.7 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна. Гэвч урсгал засварын зардлыг 117,118.5 мянган төгрөг, тэтгэмж урамшууллын зардлыг 10,407.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Гадаад, дотоод албан томилолтын зардал, худалдан авалтын зардлуудыг төсөв гүйцэтгэлүүдийг нь зэрэгцүүлэн хянасан. Батлагдсан нийт төсвөөс хэтрүүлээгүй боловч гадаад томилолтын зардлыг 9,977.4 мянган төгрөг, дотоод томилолтыг 7,395.1 мянган төгрөг нийт 17,372.5 мянган төгрөгөөр, 5 худалдан авалтын гэрээний дүн тухайн төсвөөсөө 18,400.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Хариуцсан ажилтнууд солигдсон гэсэн шалтгаанаар алба хэсгүүдээс төсөв гүйцэтгэлийг зэрэгцүүлсэн шаардлага хангасан мэдээ тайлан ирүүлээгүй нь тухайлсан гэрээний хэрэгжилт, ажил гүйлгээг хянах

дотоодын хяналт сул байна. Хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж, биелүүлэхэд цаашид анхаарч ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Дээрх түүвэрт хамрагдсан дансдын хувьд оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлагын дансдын үлдэгдэл, хөрөнгийн хөдөлгөөн, өөрийн үйл ажиллагааны орлого, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмж, урсгал засвар, томилолтын зардал, хөрөнгө оруулалтын зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дансуудын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 41.4 хувь, нийт зардлын 56.5 хувь, нийт хөрөнгийн 27.9 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлагнал:

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг салбаруудын тайлангаас 1,672,108.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Үндсэн хөрөнгийг тодруулгын тайланд худалдан авсан хөрөнгийг 3,835.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгө 1,083.8 мянган төгрөг нийт ДТ гүйлгээ 4,918.8 мянган төгрөгөөр, акталсан хөрөнгийг 2,751.2 мянган төгрөгөөр КТ гүйлгээг тус тус зөрүүтэй тайлагнасан.

Бараа материалыг тодруулгын тайланд худалдаж авсан бараа материал 21,366.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 250.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгө 77,684.0 мянган төгрөг нийт ДТ гүйлгээ 99,300.2 мянган төгрөгөөр, зарцуулсан бараа материал 11,581.8 мянган төгрөг, шилжүүлсэн 8,351.0 мянган төгрөг нийт КТ гүйлгээ 19,932.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”; Төсвийн тухай хуулийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Салбаруудын тайланг нэгтгэхэд НББОУС-27.18: “нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ толгой болон охин компаниудын санхүүгийн тайлан дахь хөрөнгө өр төлбөр, өмч, орлого болон зардлын ижил төстэй зүйл тус бүрийн дүнг мөр мөрөөр нэмнэ...” гэсний дагуу ижил үзүүлэлтүүдийг зөв нэгтгэн залруулах,

18.20: “бүлэг хоорондын дансдын үлдэгдэл, орлого болон зардлын дүнг бүгдийг нь устгаж цэвэрлэх ёстой” гэсний дагуу шилжүүлэн зарцуулсан санхүүжилт, хөрөнгүүдийг нэгтгэсэн тайланд ижил дүнтэйгээр тодруулж, тайланд цэвэрлэсэн дүнгээр залруулан тайлагнах гэсэн зөвлөмжийн дагуу аудитын явцад тайланг залруулан тайлагнасан.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан:

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн гүйлгээний тайлангаас 203,180.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Салбаруудын төсвийн зарлагын дүнг 329,281.8 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэн, батлагдсан маягтын дагуу тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.3.1 "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: СС-ын 2006 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүү, төсвийн тайлан, тодруулгын маягтуудын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлэх, Ижил төрлийн орлого, зардлуудыг нэг мөрөнд зөв нэгтгэн залруулж тайлагнах, Шилжүүлэн олгосон төсвийн санхүүжилтын дүнг хооронд нь тулган тодруулж, тайланд цэвэрлэсэн дүнгээр залруулан тайлагнах гэсэн зөвлөмжийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын явцад залруулан тайлагнасан.

3. Авлагын бүртгэл:

Авлагын дансдын 33 харилцагчийн 237,750.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх авлагаас 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 8 харилцагчийн 197,498.2 мянган төгрөгийн авлагыг тулган баталгаажуулах захидал явуулахад 1 харилцагчаас худалдан авсан хөрөнгийг орлогод бүртгээгүй 8,000.0 мянган төгрөг, эрх зүйчийн ажлын хөлс 12,600.0 мянган төгрөгийг гэрээний гүйцэтгэлийн дагуу бүртгээгүй нийт 20,600.0 мянган төгрөгийн гүйлгээг бүртгээгүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 20,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн зөвлөмжийн дагуу залруулан бүртгэж, тайлагнасан. Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан, тулган баталгаажуулах түүвэрт ороогүй 40,682.7 мянган төгрөгийн авлагын насжилтын тайланг ирүүлсэн бөгөөд 1 жилээс дээш насжилттай 6,099.5 мянган төгрөг, бусад нь тайлант оны сүүлийн улиралд үүссэн байна. Цаашид авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, насжилтаар нь тодруулан тайлагнаж байх зөвлөмж өгсөн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Дараах алдаанууд нь мөнгөн дүнгээр материаллаг хэмжээтэй боловч төсвийн зарцуулалт нийт дүнгээр хэтрээгүй тул агуулга шинж чанарын хувьд материаллаг алдаагүй гэж үзэн дүгнэлтэд нөлөөлөхгүй. Харин дахин давтагдаж болзошгүй гэж үзэн менежментийн захидалд оруулан зөвлөмж өгсөн тул энэ хэсэгт толилууллаа.

1. Худалдан авалт:

2016 оны худалдан авалт нийт дүнгээрээ батлагдсан төсвөөс хэтрээгүй ч 5 худалдан авалтын гэрээний дүн тухайн төсвөөсөө 18,400.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийг нийт дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй боловч бүлэг, ангиллын гүйцэтгэлийг хянан хэлэлцэж, тодотгол хийн батлуулж, ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэснийг хэрэгжүүлж байх шаардлагатай. Мөн тус байгууллагын худалдан авалтын ажилтнууд солигдсон гэсэн шалтгаанаар шаардлага хангасан тайлан ирүүлээгүй болно.

1. Төсвийн зарцуулалт:

Орон тоо бүтцийн өөрчлөлтөөр ажлаас халагдсан ажилтнуудын 1 удаагийн тэтгэмж 53,292.3 мянган төгрөг, сувиллын зардал 929.3 мянган төгрөг, шүүхийн шийдвэрээр 2 ажилтанд олгосон тэтгэмж 8,498.0 мянган төгрөг нийт 62,719.6 мянган төгрөгийн зардлыг цалингийн зардлаар тайлагнасан,

Батлагдсан төсвөөс гадаад томилолтын зардлыг 9,977.4 мянган төгрөг, дотоод томилолтыг 7,395.1 мянган төгрөг нийт 17,372.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь тус тус Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардалд тайлагнасан тэтгэмжийн зардал 51,219.3 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд зөвлөмжийн дагуу залруулан тайлагнасан. Томилолтын зардлыг олгохдоо төсвийг хянаж байгаа боловч тайлангийн эцэст журналаар бүртгэсэн томилолтын зардлын гүйцэтгэлийг тухайн төсөвтэй нь зэрэгцүүлэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өглөө.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын бүртгэл:

Өмнөх оны дутуу байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 17,461.5 мянган төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэн тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 6.1 "Аж

ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэснийг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн нь: НББОУС 8.43 “алдааны тодорхой тайлант хугацаанд үзүүлэх нөлөө эсвэл хуримтлагдсан нөлөөг тодорхойлох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд өмнөх тайлант үеийн алдааг өмнөх үе рүү дахин тайлагнаж залруулна” гэсний дагуу тайлант оны эхний үлдэгдэлд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан ашигийн дансанд 17,461.5 мянган төгрөгийг залруулан тайлагнах зөвлөмжийг аудитын явцад хэрэгжүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Тус байгууллагын удирдлагууд дараах асуудлуудыг 2017 онд хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллах:

1. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр айлын орон сууцны барилга барихаар 140,000.0 мянган төгрөгийн төсөв батлуулан 141,791.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Дээрх дуусаагүй барилгыг авлагаар бүртгэснийг гүйцэтгэгч компанид тулган баталгаажуулах захидалд илгээн үлдэгдлийг баталгаажуулсан хэдий ч ирэх онд барилгыг бүрэн дуусгуулж хүлээн авч, ашиглалтанд оруулахад анхаарч ажиллах
2. Арилжааны банкин дахь долларын харилцах дансанд үлдэгдэлтэй байгаа ам долларын үлдэгдлийг тайлант оны эцэст хаалтын ханшаар бүртгэн тайлагнаснаас үүссэн ханшийн зөрүү нь танай байгууллагын мөнгөн хөрөнгийн өнөөгийн үнэ цэнээр бүртгэсэн дүн тул бодитоор хэрэгжүүлж алдагдалгүй төгрөгийн харилцах дансанд ирэх онд шилжүүлэн бүртгэхэд анхаарах

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Үндсэн үйл ажиллагааны орлого 1,456,312.5 мянган төгрөг төвлөрүүлэх төсөв батлагдсанаас 1,198,617.1 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөө 257,695.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Монголын телевизүүдийн холбооноос “... арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийг Радио телевизийн үндэсний сүлжээгээр үнэ төлбөргүй дамжуулна ..” гэсэн мэдээллийг ямар нэг эрх бүхий байгууллагын шийдвэргүй заралсантай холбоотой телевизүүд 2016 оны 4 дүгээр сараас эхлэн төлбөрөө төлөхгүй байгаа бөгөөд хэрэв төлбөр төлөхөөр бол гэрээгээ цуцлана гэсэн албан бичгүүд ирүүлсэн байна.

Тус байгууллага нь ирэх онд дээрх асуудлыг шийдвэрлэтэл балансын гадуур борлуулалтын авлага бүртгэж байгаа бөгөөд хууль хяналтын байгууллагад хандвал үйлчлүүлэгч, хэрэглэгчгүй болж үйл ажиллагаа доголдохоос мөн их хэмжээний найдваргүй авлага үүсэхээс болгоомжилж байгаа талаар тайлбар ирүүлсэн.

Иймд дараагийн аудитаар дээрх гэрээний хэрэгжилтийг нарийвчлан хянах болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 200,025.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч залруулах зөвлөмж

өгснийг үйлчлүүлэгчийн удирдлага бүрэн зөвшөөрч 1,824,742.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Балансын гадуур бүртгэлтэй борлуулалтын авлага 240,825.2 мянган төгрөг, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 48,051.2 мянган төгрөгийн зөрчил нь залруулагдаагүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд манай компани аудит хийж аудитаар 3 асуудлаар зөвлөмж өгснийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлжсэн байна.

Тайлбар захидал

АОУССтандарт 580-ын дагуу үйлчлүүлэгчийн удирдлагаас бид энэхүү санхүүгийн тайланг стандарт, хууль журамд нийцүүлэн бэлтгэсэн талаарх хариуцлагыг хүлээх болон гаргаж өгсөн баримт нотолгоонууд бүрэн гүйцэд үнэн зөв гэдгийг баталсан удирдлагын хариуцлагын захидлыг 2017.03.23-ны өдөр албан бичгээр гаргуулан авч хавсаргалаа.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



МТШХХГ-ЫН ХАРЪЯА “РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УТУГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1	
Санхүүгийн тайлагнал.....	2
Асуудал 2	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
Асуудал 3	
Авлагын бүртгэл.....	4

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 4	
Худалдан авалт.....	5
Асуудал 5	
Төсвийн зарцуулалт.....	6
Асуудал 6	
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал.....	7

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Радио Телевизийн Үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Радио Телевизийн Үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг салбаруудын тайлангаас 1,672,108.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Үндсэн хөрөнгийг тодруулгын тайланд худалдан авсан хөрөнгийг 3,835.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан хөрөнгө 1,083.8 мянган төгрөг нийт ДТ гүйлгээ 4,918.8 мянган төгрөгөөр, акталсан хөрөнгийг 2,751.2 мянган төгрөгөөр КТ гүйлгээг тус тус зөрүүтэй тайлагнасан.

